



**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар A/09

Улаанбаатар хот

┌ Монголын хүүхдийн спортын VII наадмыг ┐
дүүрэгт зохион байгуулж, шигшээ тэмцээнд оролцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Биеийн тамир спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоол, 2021 оны 268 дугаар тогтоол, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/29 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын хүүхдийн спортын VII наадмыг Баянзүрх дүүргийн хэмжээнд нэгдсэн зааврын дагуу 2023 оны 02 дугаар 16-наас 05 дугаар сарын 20-ны хооронд зохион байгуулж, шалгарсан тамирчдыг шигшээ тэмцээнд 2023 оны 06 дугаар сарын 19-нөөс 28-ны өдрүүдэд оролцуулсугай.

2. Тэмцээний зардалд 80,032,900 (Наян сая гучин хоёр мянга есөн зуун) төгрөгийн төсвийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Спортын хэлтсийн дарга (Ю.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНСҮРЭН

2030923024